



ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС












БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2018 оны эхний 2 сард



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2014-2018 ОН	3
 АЖ ҮЙЛДВЭР	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД	8
 ЭРҮҮЛ МЭНД	9
 ГЭМТ ХЭРЭГ	10
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	13
 ҮНЭ ХАНШ	14

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Малын тоо, 2017 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		1	2	3	4	5
Нийт мал	172049	42856	11964	43683	47027	26519
Үүнээс:						
Тэмээ	224	70	-	152	2	-
Адуу	13391	3882	696	3354	3092	2367
Үхэр	14563	3947	1221	3344	3631	2420
Хонь	88526	21268	6129	22426	25634	13069
Ямаа	55345	13689	3918	14407	14668	8663

Хүснэгт 2. Хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014.II	2015.II	2016.II	2017.II	2018.II
Суурин хүн ам	тоо	28333	28419	28973	28787	
Төрөлт	тоо	130	110	131	73	104
Нас баралт	тоо	31	31	28	23	20
Шилжиж ирсэн	тоо	163	156	188	168	109
Шилжиж явсан	тоо	158	158	196	182	164
Цэвэр өсөлт	хувь	0.35	0.28	0.36	0.17	0.29'
Механик өсөлт	хувь	0.02	-0.01	-0.03	-0.05	-0.19'

' – өмнөх оны суурин хүн амаас тооцов



АЖ ҮЙЛДВЭР


Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2018 оны эхний 2 сард 30.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.7 (6.1%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт


Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2017.II	2018.II	$\frac{2018}{2017}$ %	2017.II	2018.II	$\frac{2018}{2017}$ %
Нүүрс олборлолт	м.тн	914.7	966.6	105.7	26983.6	28514.7	105.7
Дулаан дамжуулалт	м.гкал	48.8	54.4	111.5	1458.5	1665.3	114.2
Талх үйлдвэрлэлт	тн	19.7	19.9	101.0	27.7	27.4	98.9
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	14.2	15.0	105.6	55.7	66.6	119.6

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн биет хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 51.9 (5.7%) мянган тонноор, дулаан дамжуулалт 5.6 (11.5%) мянган гкалаар, талх үйлдвэрлэлт 0.2 (1.0%) тонноор, нарийн боов үйлдвэрлэлт 0.8 (5.6%) тонноор тус тус өссөн байна.


Зураг 1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөг, сараар



Зураг 2. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, сараар, мянган төгрөг



Зураг 3. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн 2 сард



Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг үнийн дүнгээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 1531.1 (5.7%) сая төгрөгөөр, дулаан дамжуулалт 206.8 (14.2%) сая төгрөгөөр, нарийн боов үйлдвэрлэлт 10.9 (19.6%) сая төгрөгөөр тус тус өссөн бол талх үйлдвэрлэлт 0.3 (1.1%) сая төгрөгөөр буурсан байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ

2018 оны эхний 2 сард нийгмийн даатгалын сангийн орлого 2847.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 436.1 (18.1%) сая төгрөгөөр өссөн бол зарлага 3348.5 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 317.6 (8.6%) сая төгрөгөөр буурсан байна.

Нийт орлогын 1756.3 (61.7%) сая төгрөг тэтгэврийн сангаас, 200.0 (7.0%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 309.0 (10.9%) сая төгрөг ҮОМШӨ сангаас, 536.1 (18.8%) сая төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 46.4 (1.6%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017		2018		$\frac{2018.II}{2017.II} \%$	$\frac{2018.I-II}{2017.I-II} \%$
	II	I-II	II	I-II		
Сангийн орлого, бүгд	1270.2	2411.7	1290.2	2847.8	101.6	118.1
тэтгэврийн сан	781.1	1484.1	797.0	1756.3	102.0	118.3
тэтгэмжийн сан	87.8	166.8	91.0	200.0	103.6	119.9
ажилгүйдлийн сан	21.9	41.0	21.2	46.4	96.8	113.2
ҮОМШӨ-ний сан	139.2	262.9	140.5	309.0	100.9	117.5
ЭМД-ын сан	240.2	456.9	240.5	536.1	100.1	117.3
Сангийн зарлага, бүгд	1856.5	3666.1	1728.4	3348.5	93.1	91.3
тэтгэврийн сан	1203.9	2505.0	1491.1	2861.1	123.9	114.2
тэтгэмжийн сан	70.9	142.3	77.8	173.6	109.7	122.0
ҮОМШӨ-ний сан	147.8	294.3	143.4	270.7	97.0	92.0
ЭМД-ын сан	401.0	653.0	-	-	-	-
ажилгүйдлийн сан	32.9	71.5	16.1	43.1	48.9	60.3

Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4109 хүнд 2861.1 сая төгрөгийн тэтгэвэр, 568 хүнд 173.6 сая төгрөгийн тэтгэмж, 270 хүнд 270.7 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 28 хүнд 43.1 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.




НИЙГМИЙН ХАЛАМЖ

2018 оны эхний 2 сард нийгмийн халамжийн сангийн орлого 979.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 240.2 (32.5%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 518.5 (53.0%) сая төгрөг улсын төсвөөс, 458.4 (46.8%) сая төгрөг орон нутгийн төсвөөс, 2.4 (0.2%) сая төгрөг бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.

Зураг 6. Нийгмийн халамжийн сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 483 хүнд 133.4 сая төгрөгийн тэтгэвэр, 498 хүнд 68.0 сая төгрөгийн тэтгэмж, 410 жирэмсэн эхчүүдэд 22.6 сая төгрөгийн тэтгэмж, “Алдарт эх”-ийн одонтой 1696 эхчүүдэд 227.1 сая төгрөг, 1138 эх “Цалинтай ээж” хөтөлбөрт хамрагдаж 106.2 сая төгрөг, 1259 ахмадуудад 105.3 сая төгрөгийн насны хишиг олгосон байна.

Ахмад дайчин, гавьяат цолтой 15 хүнд 4.6 сая төгрөг, 1603 ахмад настанд 42.0 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, 2697 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 65.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 113 иргэдэд 7.2 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал, сая төгрөг

Үзүүлэлт	2017		2018		2018.II% 2017.II	2018.I-II% 2017.I-II
	II	I-II	II	I-II		
Сангийн орлого	554.1	739.1	516.9	979.3	93.3	132.5
Улсын төсвөөс	379.6	385.6	335.0	518.5	88.3	134.5
Орон нутгийн төсвөөс	171.9	350.7	180.7	458.4	105.1	130.7
Бусад орлого	2.6	2.8	1.2	2.4	46.2	85.7
Сангийн зарлага	468.9	600.6	501.3	782.1	106.9	130.2
Тэтгэвэр	59.4	122.4	67.7	133.4	114.0	109.0
Тэтгэмж	39.0	66.4	35.6	68.0	91.3	102.4
"Алдарт эх" I одонт эхчүүд	121.2	121.2	114.6	114.6	94.6	94.6
"Алдарт эх" II одонт эхчүүд	100.5	100.5	112.5	112.5	111.9	111.9
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	20.0	42.4	11.0	22.6	55.0	53.3
Насны хишиг	91.5	91.5	34.5	105.3	37.7	115.1
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	3.7	5.3	2.6	4.6	70.3	86.8
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	15.4	18.7	24.8	42.0	1.6*	2.2*
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	4.1	5.4	2.7	7.2	65.9	133.3

“Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөр	12.5	25.1	32.5	65.5	2.6*	2.6*
Цалинтай ээж	-	-	62.7	106.2	-	-
ОНО-д түшиглэсэн халамж	-	-	-	-	-	-
Бусад үйлчилгээ	1.6	1.7	0.1	0.2	6.3	11.8

*дахин их



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


2018 оны 2 сарын эцэст дүүргийн хэмжээнд ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 513 бүртгэгдсэний 277 (54.0%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 7. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн



Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 141 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 78 (55.3%) нь эмэгтэйчүүд байна. Мөн энэ хугацаанд 4 иргэн ажилд зуучлуулан орсон ба хязгаарлагдмал хариуцлагатай компанид 1, төсөвт байгууллагад 3 иргэн тус тус ажилд орсон байна.

Зураг 8. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр



Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа иргэдийн 100 (19.5%) нь 16-24 насны, 195 (38.0%) нь 25-34 насны залуучууд, 115 (22.4%) нь 35-44 насныхан, 93 (18.1%) нь 45-60 насны, 10 буюу (1.9%) нь 60-аас дээш насны ажилгүй иргэд байна.

Ажил идэвхтэй хайж буй иргэдийн 123 (31.6%) нь дээд боловсролтой, 32 (8.2%) нь тусгай дунд боловсролтой, 37 (9.5%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 296 (76.1%) нь бүрэн дунд боловсролтой, 17 (4.4%) нь бүрэн бус дунд боловсролтой, 8 (2.0%) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ.




ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2018 оны эхний 2 сард 111 эх амаржиж, 113 хүүхэд төрүүлснээс бусад аймаг орон нутаг, дүүргийн харьяат 23 эх амаржсан байна. Энэ хугацаанд 40436 хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 3969 (10.8%) хүнээр, 1417 хүн хэвтэн эмчлүүлсэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 74 (5.5%) хүнээр тус тус өссөн байна.

Хүснэгт 6. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2017 I-II	2018 I-II	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	31	41	10
Заг хүйтэн	13	17	4
Тэмбүү	10	11	1
Мөөгөнцөр /кандидоз/	-	1	1
Трихомониаз	8	10	2
Кандилом	-	2	2
Цочмог халдварт өвчин	45	36	-9
Гепатит А	2	2	-
Скарлатин	1	-	-1
Салхин цэцэг	35	28	-7
Крансух	-	1	1
Корь	1	-	-1
Хачигт рикеттиоз	1	-	-1
Рож	1	-	-1
Гар хөл амны өвчин	-	1	1
Сүрьеэ	4	4	-
Нийт халдварт өвчин	76	77	1

Зураг 9. Халдварт өвчин, сараар



2018 оны эхний 2 сард халдварт паразит өвчний 41 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 53.2%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 10 (32.3%) тохиолдлоор өссөн бол цочмог халдварт өвчний 36 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 46.8%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 9 (20.0%) тохиолдлоор буурсан байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 26.6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 продицимиллээр өссөн байна.



ГЭМТ ХЭРЭГ

2018 оны эхний 2 сард дүүргийн хэмжээнд 55 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 25 (83.3%) хэргээр өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 27.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 43.5 пунктээр доогуур байна.


Хүснэгт 7. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2017.ИИ	2018.ИИ	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	30	55	25	83.3	100.0
Хүний амь нас хохироох	-	-	-	-	-
Хүний амь нас хохирсон	-	2	2	-	3.6
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	15	24	9	60.0	43.6
Гэр бүлийн хүчирхийлэл	2	1	-1	-50	1.8
Бэлгийн халдашгүй байдал	-	1	1	-	1.8
Бусдын эд хөрөнгө хулгайлах	4	13	9	3.2 ¹	23.6
Бусдын эд хөрөнгө дээрэмдэх	-	1	1		1.8
Залилан мэхлэх	1	2	1	100.0	3.6
Гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх	-	2	2	-	3.6
Эд хөрөнгө устгах гэмтээх	-	3	3	-	5.5
Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах	-	1	1	-	1.8
Мал хулгайлах	2	2	-	-	3.6
Мөнгөн тэмдэгт хуурамчаар бэлтгэх	-	2	2	-	3.6
Орчиндоо аюул учруулах, амьтныг зохих хамгаалалтгүй орхих	2	-	-2	-100.0	-
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	1	1	-		1.8
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	3	-	-3	-100.0	-
Хэрэг илрүүлэлтийн хувь	71.4	27.9			

¹ – дахин их

Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнхийг буюу 43.6 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 23.6 хувийг бусдын эд хөрөнгө хулгайлах хэргүүд эзэлж байна. Тайлант хугацаанд эд хөрөнгө устгах гэмтээх хэрэг 3, хүний амь нас хохирсон хэрэг, залилан мэхлэх, гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх, малын хулгайн хэрэг, мөнгөн тэмдэгт хуурамчаар бэлтгэх хэрэг тус бүр 2, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн халдашгүй байдлын хэрэг, бусдын эд хөрөнгө дээрэмдэх, болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, хууль сахиулагчийг эсэргүүцэх хэргүүд тус бүр 1 бүртгэгдсэн байна.


Зураг 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Хүснэгт 8. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2017.II		2018.II	
	согтуугаар	гудамж талбайд	согтуугаар	гудамж талбайд
Бүгд	11	8	24	10
Хүний амь нас хохирсон	-	-	-	1
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	9	3	20	4
Гэр бүлийн хүчирхийлэл	1	-	1	-
Бэлгийн халдашгүй байдал	-	-	1	-
Бусдын эд хөрөнгө хулгайлах	-	1	-	-
Бусдын эд хөрөнгө дээрэмдэх	-	-	-	1
Гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх	-	-	-	1
Эд хөрөнгө устгах гэмтээх	-	-	1	1
Болгоомжгүй эд хөрнгө устгах	-	-	-	1
Орчиндоо аюул учруулах, амьтныг зохих хамгаалалтгүй орхих	-	2	-	-
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	1	2	1	1
Дүнд эзлэх хувь	36.7	26.7	43.6	18.2

Зураг 11. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, сараар




Зураг 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний 2 сард



Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 24 болж өмнөх оны мөн үеэс 10 (2.2 дахин) хэргээр, гудамж талбайд 10 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 (25.0%) хэргээр тус тус өссөн байна.

Харин согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 43.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.9 пунктээр нэмэгдсэн бол гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 18.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.5 пунктээр доогуур байна.

Зураг 13. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн эхний 2 сард



НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 270.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.7 (2.2%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 217.3 (80.4%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 9. Орон сууц нийтийн аж ахуйн орлого, сая төгрөг


Үзүүлэлт	2017.II	2018.II	Өсөлт бууралт
Нийт орлого	264.5	270.2	5.7
Орон сууц	32.8	33.5	0.7
Ус борлуулалт, бүгд	121.6	120.5	-1.1
хүн амд	72.7	67.6	-5.1
аж ахуйн нэгжид	47.4	51.4	4
үйлчилгээний байгууллагад	1.5	1.5	0
Сувагжуулалт	94.3	93.6	-0.7
Бусад	15.8	22.5	6.7

Зураг 14. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг



Хүснэгт 10. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт, мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
Нийт дүн	78754.7	71535.5	90.8
Үүнээс:			
Тавлаг өргөө	13670.0	11453.3	83.8
Маргад өргөө	13218.0	13270.0	100.4
Сод хөгжил	16852.2	14034.9	83.3
Шинэ элч	15248.8	14403.5	94.5
Уурхайчин	8290.0	8799.3	106.1
Содон суварга	11475.7	9574.5	83.4



ҮНЭ ХАНШ


2018 оны 2 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

Хүснэгт 11. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2018 оны 2 сарын дундаж үнэ


№	Хүнсний бараа		Хэмжих нэгж	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	В&М супер маркет	Шинэ зах
1	"Алтан тариа" гурил	Дээд	кг	1400	1300		1300	1300
		I зэрэг	кг	1100	1100		1100	1100
		II зэрэг	кг	900	900		900	900
2	Будаа	цагаан	кг	2350	2100		2200	2300
		шар	кг	1200	1200		1200	1200
3	Хонины мах	ястай	кг			5375		5375
		цул	кг			6375		6375
4	Үхрийн мах	ястай	кг			6313		6313
		цул	кг			7313		7313
5	Адууны мах, ястай		кг			4813		4813
6	Ямааны мах		кг			5125		5063
7	Элсэн чихэр		кг	2150	2200		2300	2200
8	Сүү /задгай/		л	2250				
9	Тараг /задгай/		л	-				
10	Цөцгийн тос, Орос		кг	3500	3400		3400	
11	Байцаа		кг			1500	1500	1500
12	Манжин		кг			3000	3000	3000
13	Төмс	монгол	кг			975	975	1000
14	Лууван	монгол	кг			1800	1800	1800
15	Сонгино	хятад	кг			1500	1400	1400
		монгол	кг			3000	3000	3000
16	Сармис, булцуу		ш			350	350	350
17	Огурцы, хятад		кг			5500	5500	5500

18	Помидор, хятад /үрлэн/	кг			6000	6000	6000	
19	Ургамлын тос/ sunny gold/	ш	3550	3450		3500	3500	
20	Өндөг	ш	380	350		350	330	
21	Талх	буриад	том 900 гр	ш	1600	1600	1600	1600
			Дунд 700 гр	ш	1400	1400	1400	1400
			жижиг 500 гр	ш	1100	1100	1100	1100
		Есөн шанд /дунд/	ш	1500	1500	1500	1500	
		Атар талх	ш	1200	1200	1200	1200	

Зураг 15. “Алтан тариа” гурилын үнэ, жил бүрийн 2-р сард



Зураг 16. Нэг кг цул махны үнэ, жилийн бүрийн 2-р сард



Хүснэгт 12. Үйлчилгээний үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжин нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)
Дулаан	1м ²	600	1м ³	983
Дулааны суурь тариф	40 м ² хүртэл	3 000		
	40м ² - 80м ²	5 000	-	-
	81м ² -аас дээш	10 000		

Халуун ус	Өвөл	1 хүн (тоолуургүй)	2 875	1 гкал	69 647
		1м ³ (тоолууртай)	1 484		
	Зун	1 хүн (тоолуургүй)	4 025		
		1м ³ (тоолууртай)	1 484		
Цэвэр ус*	1 хүн (тоолуургүй)	0.8	1 л (тоолуургүй)	1.50	
	1 л (тоолууртай)	0.65	1 л (тоолууртай)	1.20	
	суурь хураамж	1 800	1 л (зөөврөөр)	5.45	
Бохир ус*	1 хүн (тоолуургүй)	0.77	1 л (тоолуургүй)	1.50	
	1 л (тоолууртай)	0.63	1 л (тоолууртай)	1.20	

*2017 оны 9 сарын 15-наас мөрдөж байгаа тариф

Хүснэгт 13. Цахилгааны үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	98.4
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	118.2
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	104.3
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	77.1
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	128.5
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	209.8
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1
3 тарифт тоолууртай /уул уурхай, үйлдвэрийн газар/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	155.9
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	276.0
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1

* 2015 оны 7 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй тариф

Хүснэгт 14. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2015. II	2016. II	2017. II	2018. II	Өөрчлөлт	
					төгрөг	хувь
АИ -76,80	1560	1532	1480	1600	120	8.1
АИ -92,93	1700	1660	1630	1735	105	6.4
Дизель түлш	1830	1782	1720	2033	313	18.2

2018 оны 2 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд АИ-80 бензин 120 төгрөгөөр (8.1), АИ-92 бензин 105 төгрөгөөр (6.4), дизель түлш 313 төгрөгөөр (18.2) тус тус өссөн байна.


Зураг 17. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ, (чиглэл: УБ-БН, БН)



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2018 оны 3 дугаар сарын 14-ны өдөр

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах **ezStat** аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
МОНСТАТ аппликейшн



Download on the
App Store

Google play



Утсаар:



Лавлах утас

1900-1212